

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ГУЧИН-УС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛААС ЗОХИОН БАЙГУУЛСАН НИЙТИЙН СОНСГОЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр

№2025/01

Аргуут

Нийтийн сонсгол Гучин-Ус сумын Засаг даргын Тамгын газрын Иргэний танхимд 2025 оны 04 дүгээр сарын 18-ний өдрийн 15 цаг 02 минутад эхлэв.

Нийтийн сонсголын сэдэв: “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2024 онд гүйцэтгэсэн ажлын хэрэгжилтэд”-д хийх төсвийн хяналтын сонсгол.

Сонсгол даргалагчаар Төсөв, санхүү эдийн засгийн бодлогын хорооны дарга Ц.Наранбаатар ажиллаа.

Сонсголд тайлбар мэдээлэл өгөхөөр дуудагдсан төрийн байгууллага, албан тушаалтнаар:

1. Сумын Засаг дарга Х.Энхтайван
2. ЗДТГ-ын дарга Н.Тунгалаг
3. Сумын төсвийн ерөнхий нягтлан бодогч Д.Нэргүй нар

оролцож байна.

Хүрэлцэн ирээгүй албан тушаалтан байхгүй, бүгд ирсэн байна.

Журмын дагуу бүртгүүлж оролцох оролцогчдыг танилцуулъя. Үүнд:

1. Сонсголд оролцож санал хэлэх, тайлбар, мэдээлэл өгөх оролцогчоор
 - Эрүүл мэндийн төвийн жолооч Д.Баярсайхан
 - Цэцэрлэгийн эрхлэгч Р.Содвообавуу
 - ЕБС-ийн багш Д.Үүрцайх
 - Б.Мягмарбат- иргэн
 - Т.Дашзэвэг- иргэн
 - Ж.Цэнд -иргэн
 - ЭМТ-ийн нярав- Ч.Бодьсайхан
 - ЕБС-ийн багш Г.Алтанцацрал нар бүртгүүлсэн.

Ажиглагчаар оролцохоор нийт 14 хүн бүртгүүлснээс 10 хүн ирсэн байна.

Сонсгол даргалагчийн зүгээс заавал оролцуулахаар урьсан олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, тухайн асуудлаар мэргэшсэн мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага байхгүй болно.

Сонсгол даргалагч Ц.Наранбаатар сонсголын дэгийг танилцуулав.

Сонсголд дуудагдсан оролцогч **“Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2024 онд гүйцэтгэсэн ажлын хэрэгжилт”**-ийн талаар сумын төсвийн ерөнхий нягтлан бодогч Д.Нэргүй танилцуулга хийнэ. 15 минутаас дээшгүй байна.

Д.Нэргүй: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Мэдээлэл хүргэхийн өмнө ОНХ-ийн сан гэж юу вэ? гэдэг талаас мэдээлэл өгье. ОНХ-ийн сан гэдэг бол Засгийн газраас ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон малын тоо толгойн албан татвараас бүрдсэн орлогыг иргэдийн саналд үндэслэж орон нутгийн хөгжлийг дэмжих мөн тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд ОНХ-ийн сан дэмждэг. ОНХС-ийн зорилго гэж юу вэ? гэхээр орон нутгийн хөгжлийг дэмжих иргэдийг тогтвор суурьшилтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд энэ сангийн зорилго оршиж байгаа юм. ОНХС-ийн ажлуудад юу юу шаардаж байна вэ? гэсэн асуулт гарч ирэх юм. Энэ бол урт болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй хийх хөрөнгө оруулалтын бодлогын санд иргэдийн саналаар дэмжигдсэн саналыг ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийнэ. Мөн зураг төсөл болон байгаль орчны эдийн засгийн үнэлгээ, хууль тогтоомж зөрчөөгүй зүйл энэ сангаар хийгдэнэ. ОНХС-ийн

хөрөнгө оруулалтаар хийж болохгүй зөвшөөрөгдөөгүй ажилд дараах 6 ажил ордог. Үүнд:

1. Улс төрийн нам эвсэл түүний харьяа төрийн бус байгууллагын зарлага санхүүжилт.

2. Үндэсний их баяр наадмаас бусад баяруудыг уг санхүүжилтээр санхүүжүүлж болохгүй.

3. Нийтийн эрх ашигт нийцээгүй цөөн тооны иргэдийн эрх ашгийг хамгаалсан зүйлийг мөн санхүүжүүлж болохгүй.

4. Зээл олгох баталгаа гаргах зэрэг хохирлын мөнгөн төлбөрүүдийг уг санхүүжилтээр санхүүжүүлж болохгүй.

5. Жилийн төлөвлөгөөнд тусгаж багтаагүй хөрөнгө оруулалт, иргэдийн саналыг аваагүй хөрөнгө оруулалт

6. Аливаа аж ахуй нэгж байгууллагуудад буцалтгүй тусламж, урамшууллыг уг сангаас гаргахыг хориглодог. Эдгээрээс бусад санхүүжүүлэх эх үүсвэрийг санхүүжүүлдэг сан юм. ОНХС-ийн санхүүжилт нь дараах 3 хамаарлаас хамаараад санхүүжигддэг байна.

1. Хүн амын тооноос хамаарна

2. Газар нутгийн алслалаас хамаарна

3. Нутаг дэвсгэрийн талбайн хэмжээнээс хамаарна. 2024 оны хувьд хүн амын тооноос хамаарч 44,800.0 мянган төгрөг, Газар нутгийн алслалтаас хамаарч 216.000,0 мянган төгрөг, тогтвортой амьжиргаа 3 төслийн урамшуулал 62.200,0 мянган төгрөг, Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр хураамжаас 6.200,0 мянган төгрөг, ашигт малтмалын ашиглалтын талбайгаас 222.700,0 мянган төгрөг тус тус байна. Энэ таван үзүүлэлтээс ОНХС-ийн орлогын шилжүүлэг бүрдэж байна. Малын тоо толгойн албан татварын орлогоос 105,000.0 мянган төгрөг, бүгд 2024 онд орлогын шилжүүлэг, малын тоо толгойн албан татвар нийлээд 786.700,0 мянган төгрөгийн төсөв батлагдсан. 2024 онд дараах ажлууд хийгдсэн. Үүнд:

Санхүүжилтийн гүйцэтгэл ОНХС-ийн дээрх 5 зүйлээс 100 хувь санхүүжилт авсан байгаа. Харин малын тоо толгойн албан татвар 83.200,0 мянган төгрөг авч нийт орлогын гүйцэтгэлийн санхүүжилт нь 95.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Малын тоо толгойн албан татвараас 35.800,0 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан байгаа. Малын тоо толгойн санхүүжилт 4.500,0 мянган төгрөг дутуу авсан юм. ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийх ажлууд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахтай уялдаж хуулийн дагуу худалдан авалтууд нь хийгддэг.

• Газар тариалангийн чиглэлээр ажиллах иж бүрэн тоног төхөөрөмжийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан байгаа. Нээлттэй гэдэг нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн босго үнийг Монгол Улсын Засгийн газрын тогтоол байгаа. Босго үнэ нь бараа ажил үйлчилгээ 20.000,0 мянган төгрөг дотроо шууд худалдан авалт хийж болно. 20,000.0 мянган төгрөгөөс давсан бараа нь 100,000.0 мянган төгрөг, ажил 150,000.0 мянган төгрөг, үйлчилгээ нь 100,000.0 мянган төгрөгөөс дээш өртөгтэй хөрөнгө оруулалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар хийдэг. Энэ тоног төхөөрөмжийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан. Үүнд 2 ААН-ээс үнийн санал ирүүлсэн. 2 компани тендерийн шаардлага хангасан байсан. Алтан цамхаг андоз 3.000,0 мянган төгрөгийн дутуу санхүүжилт ирүүлж бага үнийг

саналаар буюу 147.0 сая төгрөгөөр энэ ААН шалгарч манайд эдгээр тоног төхөөрөмжийг оруулсан байгаа.

- Лед дэлгэц худалдан авах энэ төндөрийг харьцуулалтын аргаар зарлах төндөрийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарлаж болдог. 50,000.0 мянган төгрөгийн нээлттэй тендер зарласан байгаа. Мөн 2 ААН-ээс үнийн санал ирсэн байгаа. "Их хаант групп"-ээс 47,000.0 мянган төгрөг, "Гарьд повер транс"-аас 50,000.0 мянган төгрөгөөр тендерт үнийн санал ирүүлсэн байгаа. Тендерт үнийн санал ирүүлэхдээ бага үнээс гадна манай тавьсан шаардлагыг хэр сайн хангаж байна вэ? гэдгийг авч үздэг. Гард повер транс нь хэдий өндөр үнэтэй ч манай тавьсан шаардлагыг сайн хангасан тендер ирүүлсэн байсан. Лед дэлгэц маань илүү нягтшил сайтай байсан учраас сонгож соёлын төвдөө дэлгэцтэй болсон байгаа.

- Мал ариутгалын авто машин нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан байгаа. Үүнд мөн 2 ААН-ээс үнийн санал ирүүлсэн. Жапанкапатс ХХК нь бага үнийн санал буюу 42,200.0 мянган төгрөгийн үнийн санал ирүүлсэн байсан. Энэ компани нь манай суманд мал ариутгалын авто машин нийлүүлсэн байгаа. Уг авто машин нь 3 тар руугаа цацаж ариутгадаг.

- Төрийн албан хаагчдын орон сууцны завсрын тендер харьцуулалтын аргаар зарласан. 3 ААН-ээс үнийн санал ирүүлсэн. Арвайн хийц ХХК нь 49,700.0 мянган төгрөг, Өв аргуй ХХК нь 49,500.0 мянган төгрөг, Эн эн эм би Тауэр 47,000.0 мянган төгрөгөөр тендерт үнийн санал ирүүлж шаардлага хангасан бага үнийн саналаар Эн эн Эм Би тавор ХХК нь шалгарсан байгаа.

- Гэрэлтүүлгийн төндөрийг харьцуулалтын аргаар зарласан байгаа босго үнэ нь 20,000.0 мянган төгрөгөөс дээш ажил нь 150,000.0 мянган төгрөг, бараа нь 100,000.0 мянган төгрөг дотор харьцуулалтын аргаар ажлын 5-аас дээш хоногоор тендер зарлагддаг. Энэ тендер 3 удаа зарлагдаж "Жапанкапатс" ХХК ганцаараа материал ирүүлсэн. 126 ширхэг гэрэл нийлүүлсэн.

- Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт 30,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй харьцуулалтын аргаар тендер зарласан байгаа. 2 ААН-ээс үнийн санал ирүүлсэн. "Сүүн төгрөг" ХХК нь 30,000.0 мянган төгрөгөөр, "Гэрэлт мандал шим" 29,000.0 мянган төгрөгийн тендер ирүүлсэн. Гэрэлт мандал шим ХХК нь бага үнийн саналаар шаардлага хангаж хэрэгжүүлсэн байгаа. Юу юу хийснийг та бүхний материал дээр тусгасан байгаа.

- Сумын стратеги төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер байсан. Харьцуулалтын аргаар 2 удаа зарлаж 2 дахь удаагийн зарлахад 2 компаниас үнийн санал ирүүлсэн. Өвөрхангай аймгийн залуучуудын боловсрол хөгжлийн академиас 30,000.0 мянган төгрөгийн үнийн санал, Контекст Монгол групп 25,000.0 мянган төгрөгөөр шалгарч одоо ажил нь 90 хувьтай явагдаж байна. Сумын ИТХ-аар батлуулах ажил үлдсэн байна.

- Гудамж хорооллын замыг тэгшлэх "Хас гарьд" консштракшинтай гэрээ хийж гудамж хорооллын замыг тэгшлэх эмтэрсэн замыг түрж тэгшлэх ажлыг хийсэн байгаа. Энэ ажил 19,000.0 мянган төгрөгийн өртөгтэй байсан.

- Гудамж хорооллын өнгө үзэмжийг сайжруулах, будаж цэгцлэх ажил сумын 100 жилийн ойн арга хэмжээтэй холбоотойгоор хийж гүйцэтгэсэн байгаа. Од барилга ХХК-аас материалаа авч хорооллын нийтийн эзэмшлийн хашаа, хайс будаж цэгцэлсэн байгаа.

• Ногоон байгууламж нэмэгдүүлэх ажилд шатахуун 800.0 мянган төгрөг, мод 7,900.0 мянган төгрөг, 3 ажилчдын цалин 29,000.0 мянган төгрөг зарцуулж ногоон байгууламжийн услагаа, арчилгааг хийсэн.

• Цэцэрлэгийн хүүхдийн гадна талын тоглоомын талбайн тохижилт "Ургамлын далай ХХК"-аас зориулалтын хүүхдийн тоглоомын гэрээ хийж тохижуулсан байгаа. Төсөвт өртөг нь 15,000.0 мянган төгрөгөөр шууд худалдан авсан.

• Сумын баяр наадмын зардал 15,000.0 мянган төгрөг төлөвлөгдөөд, 14,600.0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй гарч 100 жилийн ойн арга хэмжээний АА-н ажлыг хийсэн байгаа.

• Ахмадын өргөөний засвар нь 8,000.0 мянган төгрөгөөр хийсэн. "Их угалз" ХХК нь мэргэжлийн хүмүүс авчирч дулааны шугамыг сольж, шалны хулдаас дэвсэж дээрээс дусаал гоожихгүй болгож өгсөн.

• Худаг ус гаргах тендерийг харьцуулалтын аргаар зарласан байгаа. 79,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тендер зарлаж "Баян говь ус" ХХК нь ганцаараа үнийн санал ирүүлсэн. Бидний тавьсан шаардлагыг хангасан үнийн санал ирүүлсэн учир уг компанитай гэрээ хийж 2 ширхэг гүн өрмийн худаг, 1 ширхэг цооног, 2 худгийн засварын ажлыг уг өртгөөр хийж гүйцэтгэсэн. Уг санхүүжилтийн 29,000.0 мянган төгрөг нь малын тоо толгойн албан татвараас гарсан, үлдсэн санхүүжилт нь ОНХС-аас санхүүжүүлсэн байгаа.

• Малын тоо толгойн орлогоор малын тэжээлийн ургамал тариалах, үр худалдан авч малын тэжээлийн ургамал тариалсан байгаа. Төсөвт өртөг нь 15,000.0 мянган төгрөг байсан боловч 14,300.0 мянган төгрөгөөр Өнөхонгор ХХК-тай гэрээ хийж энэ жилийн ногоон тэжээл нийлүүлсэн байгаа.

• Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах гэсэн нь 19,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөг гарч 18,100.0 мянган төгрөг гарсан байгаа, Үүнд "Их угалз" ХХК, 3и пи эл ди ХХК-тай хамтарч хийсэн байгаа. Анхаарал хандуулсанд баярлалаа. Асууж тодруулах зүйл байвал асууж болно.

Сонсгол даргалагч Ц.Наранбаатар: Мэдээлэлтэй холбогдуулан бүртгүүлсэн дарааллаар асуулт асууна, асуултын хариуг өгөөд явна. Асуулт асуух хугацаа 4 минут.

Д.Баярсайхан: Сайн байцгаана уу? бүгдэд нь өдрийн мэнд. Би нэг юм асууя. Газрын тос ашиглалтын талбайгаас 222 сая гэж мэдээлэл өглөө тараах материал дээр 226 сая гэсэн байх юм аль нь үнэн мэдээлэл вэ?

Д.Нэргүй: Газрын тос ашиглалтын талбайгаас 226.7 сая төгрөг юм.

Сонсгол даргалагч Ц.Наранбаатар: Оролцогчдоос бүртгүүлсэн дарааллаар санал хэлэх, асуулт асуух хүн байна уу?

Б.Мягмарбат: Гэрэлтүүлэг нь одоо ажиллаж байгаа юм байхгүй үүнийг яах вэ?

Засаг дарга Х.Энхтайван: ОНХС-ийн 30.0 сая төгрөгөөр 150 ширхэг гэрэл гэсэн тоо гаргасан. Үүн дээр манайх 6 удаа тендер зарласан. 6 удаа зарлахад нэг ч компани орж ирээгүй. Жапанкапатс ХХК-д бид өөрсдөө гуйж оруулсан юм. Тухайн үедээ гэрэл нь асаж бид хүлээж авсан. Гэрэл нь 1 жилийн хугацаатай. Тухайн компанид бид нөхцөл байдлаа хэлсэн. Одоохондоо амжихгүй байна. Би урагшаа явж бүх сэлбэгийг авчирч янзалж өгнө гэж байгаа. Бидний зүгээс энэ нарны зай шаардлага хангахгүй байна боль гэсэн үзүүлэлт байхгүй. Хариуцсан компани нь шийдэж өгнө гэсэн байгаа учраас асуудалгүй шүү.

Д.Нэргүй: Энэ гэрэлтүүлэг нь ОНХС-ийн өөрийн санхүүжилтээр хийгдсэн.

Р.Содвообавуу: 2024 оны төсөв ярьж байхад ОНХС-нд дулааны шугамд мөнгө тавьж байсан. Тэр хэрэгжсэн үү?, Материалд байхгүй байна.

Х.Энхтайван: 2024 онд ОНХС-нд төсөв тавигдаагүй санал аваагүй. Энэ жил тавьсан байгаа. 200.0 сая төгрөг тавьж өгсөн байгаа. Яагаад тавьсан бэ гэхээр сумын бодлогын хэмжээнд тавсан шүү. Ер нь энэ халаалтын асуудлыг шахаж байгаа. Иргэн өөрсдөө оролцоотой байх ёстой. 200.0 сая төгрөгийн тендер зарлана. Дулааны компани алдагдалтай байна гэж үзэж байгаа. Жижиг 2 зуухтай. Айл болгон халаалт авахаар тийм юм байхгүй гэж байгаа. 5 сараас энэ ажил эхлэх гэж байгаа. 5 сарын 30-аас хойш бид тендерээ зарлаж байж санхүүжилтээ гаргана. Бүх зүйлээ тооцоолж байгаа.

Сонсгол даргалагч Ц.Наранбаатар: Өөр асуулт асуух оролцогч байна уу?

Ж.Бодьгэрэл: Малын тоо толгойн албан татвар 35.8 сая төгрөг дутуу байгаа гэж байна. Одоо үүнийг хэзээ яаж барагдуулах вэ?, яагаад зарим нь төлөөд зарим иргэд төлдөггүй вэ?

Мал ариутгалын авто машин гэсэн байна. Иргэд ямар хүнд хэлж хэдийд малыг яаж ариутгах вэ?

Шинээр худаг ус гаргана гэж байна. Энэ худаг ус гарах ажлыг яаж шалгаж авдаг вэ? жишээ нь усны нөөц ундрага хүчин чадал гэх м этийг яаж шалгаж авдаг вэ?

Х.Энхтайван: Малын худгыг Монгол улсын стандартад нийцсэн хэмжээ байдаг. Бэлчээрийн зориулалттай усан хангамж 0,6 байна. Манай аймаг 0,8-аас дээш байна. Мэдээж танай гадаа ч юм уу, хаана ч байсан худаг гаргах сонирхолтой байна гэвэл усны нөөцөө тодорхойлно, усгүй газар худаг гаргахгүй. Ноднин манай сум 2 худаг гаргаж, 6 цооног даруулсан. Худаг ухаж байгаа компаниуд нь эрсдэлтэй. Эрсдэлийг үүрч 2 цооног нэмж гаргаж өгсөн.

Малын тоо толгойн албан татвар сүүлийн 4 жил дүнгээрээ 30-аас дээш хувьтай л байна. Ноднин цаанаасаа албан ёсоор данс барилт хийсэн байгаа. Манай иргэд хийсэн. Уг нь малын тоо толгойн албан татвараа төлөөд явж байвал энэ сумын 2 малын эмнэлгийн үйлчилгээг сайжруулах талаар анхаарч ажиллана. Ноднин мал ариутгалын машин 7 сард ирсэн малын ноос ургасан байсан учраас ариутгал хийгээгүй юм. Үүнийг МЭУБ Б.Янжмаатай холбогдоод авах юм.

Б.Янжмаа: Мал угаах ариутгалыг 2 ААН-ээр хийлгэнэ. 4 багийн 2 ААН-дээ хувааж өгсөн байгаа. 2,3 дугаар багийг Ундрахбаяр эмч, 1, 4 дүгээр багийг Лувсандавга хариуцаж байна. Тус бүрийн хариуцаж буй багийн эмчтэй холбогдоод хотондоо мал ариутгана. Аймгийн тогтсон ханш нь нэг мал 500 төгрөгөөр ААН-тэй гэрээ байгуулж ажиллана гэсэн үг шүү. Бид төрийн зүгээс мал ариутгах тоног төхөөрөмжөөр хангаж өгч байгаа үйлчилгээг ААН-ээрээ дамжуулж авна. Малын тоо толгойн албан татвараас малын гоц халдварт өвчний вакцинжуулалтын зардал шөвөг, ярь өвчнөөс урьдчилан сэргийлэх зардал малын тоо толгойн албан татвараас гарч байгаа.

Д.Үүрцайх: 18 төрлийн ажил үйлчилгээг сумандаа хийсэн байна. Тайлангаа тавихдаа тодорхой оруулж өгөх боломж байдаг уу?, жишээ нь гудамж талбай засварласан гэж байна.Цалин хөлс яг хэд орсон, будаг хэдэн төгрөг орсон гэдэг задаргааг сайн гаргаагүй байна. 800 ширхэг хайлаас, бургас 350 гэсэн байна энэ хаана ямар талбайд тариалсан бэ?

Мод усалж арчлах гэсэн байна. Яг хаана ургаж байгаа мод вэ?

Худаг ус гаргалаа гэсэн байна. Энэ гаргаж байгаа худгаас хэчнээн мал услах боломжтой, хэдэн өрх ашиглах боломжтой гэсэн дүн байдаг уу? эдгээр тодорхой зүйлийг тайлан дээр тусгаж өгч байгаарай.

Х.Энхтайван: Сумын 100 жилийн ойн арга хэмжээтэй холбогдуулж гудамж хорооллын өнгө үзэмжийг сайжруулах, будаж цэгцлэх ажил хийгдсэн. Бид зос авчраад тогтохгүй байсан учраас үйлдвэрийн эмульс, охор авчраад л иргэдэд тарааж өгсөн. Мод услагаа болон ойн арга хэмжээнд бид нийт 8 хүн ажиллуулсан. Яг нарийн зардлыг гаргаад өгч болно.

Д.Нэргүй: Будаг, охор, тус бүрийн үнийг тусгаагүй л дээ. Цахим шилжилттэй холбоотойгоор бидний хийсэн бүх зүйлийг тендерийн сайт руу ороод иргэний зүгээс харахад бүх юм харагдаж байгаа шүү. Гэрээ, тийм компани гүйцэтгэсэн, хэдэн төгрөгийн тендер гээд бүх зүйл байдаг шүү.

Д.Үүрцайх: 30.0 сая, 29.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдээд сүүлд нь ямар ч хараа хяналт байхгүй. Цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон зүлэг хаана л бол хаана хийсээд явж байх жишээтэй. Камерын асуудлыг шийдэж болох уу?

Х.Энхтайван: Таны ярьж байгаа асуудал цэцэрлэгт хүрээлэнд их байна. Өчигдөр хүртэл хүүхдийн чуулган боллоо. Энэ янзалсан талбайг сургуулийн хүүхдүүд очиж сүйтгэдэг, мөн леги шалан дээр нь мотоциклоор 8 эргээд байхгүй болгосон. Цаад талын самбаруудыг эвдсэн байна. Өчигдөр камер харах гэсэн чинь манай тавьсан камер сунгаж явах камер байсныг бид мэдээгүй сунгаж яваагүй учраас болохгүй байна.

Д.Үүрцайх: Камерын асуудалд анхаарч өгвөл бид тухайн дутагдал гаргаж сүйтгэж байгаа хүүхдийн эцэг эхтэй уулзаж анхааруулах юм.

Д.Нэргүй: Камер ерөнхийдөө ажиллаж байгаа. Гэрэлтүүлэг нь ч ажиллана. Мөн үүн дээр хэлэхэд тавьсан төсөв нь өндөр тоо боловч манай зарлаж байгаа тендер төсөв мөнгөө дандаа тулгаж тавьдаг. Тэгэхээр манай тендер 5,6 удаа зарлалаа гэдэг нь ААН-үүдэд ашиг байхгүй. Арай гэж тендер авсан компани нь гүйцэтгэхээр хүүхдүүд нь очоод сүйтгэдэг гэх асуудал байна. Хүүхдүүдийг нийтийн эзэмшлийн талбайн эд зүйл болон хог хаягдлыг багаас нь ойлгуулах хэрэгтэй байна.

Д.Үүрцайх: Энэ асуудал залуучуудад мөн холбоотой. Архи, пивоны саваа хүртэл задгай хаяж үлдээсэн харагддаг. Сум нь 2 нийгмийн ажилтантай боллоо. Хариуцаж ажиллах хэрэгтэй байна.

Д.Баярсайхан: Тендерийг манай сум хэт тулгаж хийхээр яаж бүтээн байгуулалт нь чанартай байх вэ?, Компани нь өөрөө ашигтай байж хийнэ шүү дээ. Малын тэжээлийн ургамал тариалах гэсэн байна. Хойд талбайгаас 30 тонн өвс авсан байх юм. Үрийг тараагаад 13 өрхөд 8 тонн өвс авсан гэсэн нь их сайн ажил байна. Энэ яг талбайгаасаа 30 тонн хадлан авч чадсан уу?

Х.Энхтайван: Ер нь бид эрсдэлгүй байхыг л тооцно. Үрийг хямдралтай үнээр авсан иргэд байна. Зарим өрхүүд малын тоо толгойд тааруулах, зарим айлууд хашаалж байна. Манай тамгын газар нь "Өнөхонгор" ХХК-тай гэрээ хийсэн. 14.3 сая төгрөгийн. 1600 боодол өвс авсан юм. Ингэж л эрсдэлээ хамгаалж чадсан юм. Бид тариад ургуулж чадах уу?, мөн хаглана, бооно гээд ажил их учраас одоо бол манайх бүрэн техниктэй болсон.

Б.Мягмарбат: Газар тариалангийн тал дээр сайшаалтай зүйлүүд хийгдсэн гэж үзэж байна. Хойд талбайг ахиж ашиглах уу?

Х.Энхтайван: 10 га газарт эхний ээлжинд 1 наст тарьсан. 2 дахь ээлжинд төсөвт хөтөлбөр хэрэгжүүлж олон наст ургамал 5 га газарт, 5 га газарт нь нэг наст ургамал тариалж үзсэн тэр үед цаг муудаад малчид бутраад алга болсон. Тэр

хавийн айлуудыг газрын үр шимийг хүртэж ав гэсэн тэнд нь худаг гаргаж өгсөн, одоо шинэ техник хэрэгсэлтэй болсон. Бүх зүйл байна.

Р.Содвообавуу: Багийн төвийг ОНХС-аас засварласан уу?, Манайхаас гэр цэцэрлэг гаргадаг. Тэнд бороо ус орохоор нөхцөл нь хэцүү байна. Шавар их битүү үерлэдэг гэх мэт Зөөж болох уу?

Х.Энхтайван: Зөөх боломжтой. 3-р багийн иргэдийг газар тариалан эрхлэх боломжийг л гаргаж тэнд барьсан. Шавар усан дээр нь хайрга асгаад аргалж болно.

Сонсгол даргалагч Ц.Наранбаатар: Асуух асуулттай оролцогч байна уу?, санал, дүгнэлт хэлэх оролцогч байна уу?

Х.Энхтайван: Сумын гудамж хорооллыг тэгшлэх 19.0 сая төгрөг энэ дээр та бүхэнд хариулт өгье. Уг нь өөр компанитай гэрээ хийх гэсэн боловч төрийн өмчит компанитай гэрээ хийж болохгүй болоод энэ компани нь ажлыг сайн гүйцэтгэсэн.

Ж.Цэнд: Надад нэг санал байна. Урьд онуудад гарч байсан алдаа оноо дээрээ суралцаад ОНХС-ийн ажлуудыг цаашид үр бүтээлтэй зүйлд зарцуулаарай гэдэг саналтай байна. Үүн дээр сум орон нутгийн удирдлагууд онцгой анхаарал хандуулж, аль болохоор бага зардлаар их зүйлийг хийж байгаарай. ОНХС-аар хийж бүтээсэн ажлуудаас өөр сум орон нутгийн сайн туршлага болохуйц ажлуудыг хийж байгаарай.

Сонсгол даргалагч Ц.Наранбаатар: Бүртгүүлсэн дарааллаар өөр дүгнэлт хэлэх оролцогч байна уу?

Д.Нэргүй: Малын тоо толгойн албан татвартай холбоотойгоор нэг мэдээлэл хэлье. Малын тоо толгойн албан татвараас 2024 онд 48.5 сая төгрөгийн татвар 2025 оных дээр тусгагдаад төлөгдөөд явдаг байгаа шүү. Малчид малын тоо толгойн албан татвараа төлөх хэрэгтэй гэдгийг ойлгуулаарай.

Д.Үүрцайх: Малын тоо толгойн албан татвараа төлөхийг мэдэхгүй иргэд байдаг. Мэдэхгүйгээсээ болоод 3, 4 жил хуримтлагддаг. Үүн дээр нэг татварын байцаагч гээд цалин аваад сууж байдаг хүнээ ажлыг нь хийлгээд мэдээлэл өгүүлж байгаарай.

Д.Баярсайхан: Үүнийг жилийн эцсийн мал тооллогоор айл өрхүүдэд хэлээд яриад л явдаг шүү дээ.

Д.Нэргүй: Мэдээгүй байлаа гэхэд жилийн эцэст татварыг хэлэхгүй явах учиргүй шүү.

Сонсгол даргалагч Ц.Наранбаатар: Энэ удаагийн нийтийн сонсголын үйл ажиллагаа амжилттай явагдаж өндөрлөлөө. Эрх оны төсөвт тайлангаа төсвийн задаргааг сайн оруулж өгөөрэй.

Оролцогч, ажиглагч, мэдээлэл өгсөн төрийн албаны байгууллага хүмүүс та бүхэндээ баярлалаа.

Сонсголын үйл ажиллагаа хаасныг мэдэгдье. Та бүхэнд баярлалаа.
Нийтийн сонсгол 16 цаг 08 минутад өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН

(ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧ, СОНСГОЛ ДАРГАЛАГЧ)

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

(ИТХ-ЫН МЭРГЭЖИЛТЭН)

Ц.НАРАНБААТАР

Д.БОЛОРЧИМЭГ

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ГУЧИН-УС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛААС ЗОХИОН БАЙГУУЛСАН НИЙТИЙН СОНСГОЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр

№2025/02

Гучин-Ус сум

Нийтийн сонсгол Гучин-Ус сумын соёлын төвд 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 12 цагт 15 минутад эхлэв.

Нийтийн сонсголын сэдэв: "Малын тоо толгойн албан татвараар 2021-2024 онуудад хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн, зарцуулалт"-д хийх төсвийн хяналтын сонсгол.

Сонсгол даргалагчаар Төсөв, санхүү эдийн засгийн бодлогын хорооны төлөөлөгч Ц.Наранбаатар ажиллаж оролцлоо.

Сонсголд тайлбар мэдээлэл өгөхөөр дуудагдсан төрийн байгууллага, албан тушаалтнаар:

1. Х.Энхтайван (Сумын Засаг дарга)
2. Н.Тунгалаг (ЗДТГ-ын дарга)
3. Д.Нэргүй (төсвийн ерөнхий нягтлан)
4. Ө.Бадамзул (нягтлан)
5. А.Самбуу (сумын татварын улсын байцаагч)

Хүрэлцэн ирээгүй албан тушаалтан байхгүй, бүгд ирсэн байна.

Журмын дагуу бүртгүүлж оролцох оролцогчдыг танилцуулъя. Үүнд:

1. Сонсголд оролцож санал хэлэх, тайлбар, мэдээлэл өгөх оролцогчоор

- З.Мөнхбаяр- 1 дүгээр багийн иргэн, ИТХ-ын төлөөлөгч
- Д.Сээсрэгдорж (өндөр настан)
- Ч.Чулуунчимэг (малчин)
- М.Баяртогтох (малчин)
- Ү.Алтанзул (малчин)
- Ж.Бодьгэрэл (4-р багийн иргэн)
- Д.Дэнсмаа (ХХЭ)
- С.Даваадолгор (сумын ТӨК-ийн ажилтан, 3-р багийн ИНХ-ын дарга)
- М.Сандолгор (1-р багийн иргэн малчин)
- Н.Чүлтэмгямцай (1-р БЗД)
- О.Батмөнх (малчин)
- Б.Нямдаваа (төрийн банкны ажилтан)
- Ч.Гүндэндэжидмаа (малчин)
- Д.Хулганаа (малчин) нар оролцож байна.

Ажиглагчаар оролцохоор нийт 19 хүн бүртгүүлснээс 17 иргэн ирсэн байна.

Сонсгол даргалагчийн зүгээс заавал оролцуулахаар урьсан олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, тухайн асуудлаар мэргэшсэн мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага байхгүй болно.

Сонсгол даргалагч Ц.Наранбаатар сонсголын дэгийг танилцуулав.

Сонсголд дуудагдсан оролцогч "Малын тоо толгойн албан татвараар 2021-2024 онуудад хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн, зарцуулалт"-ын талаар татварын улсын байцаагч А.Самбуу танилцуулга хийнэ.15 минутаас дээшгүй байна.

А.Самбуу: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Та бүхэнд урьдчилан 2021-2024 онуудад иргэдийн малын тоо толгойн аблан татварын төлөлтийг өрх бүрээр гаргасан материал тараасан байгаа.Малын тоо толгойн албан татварын хувьд манай сумын ИТХ-аас хамгийн сүүлд 2023 онд шинэчлэн тогтоосон байгаа. Арай буурсан.2021, 2022

оны татвараа тухайн үеийн татварын тогтсоноор төлөх юм шүү.Одоо та бүхэд 2021-2024 онд багуудын малын тоо толгойн албан татварын орлогын гүйцэтгэлийг танилцуулъя.

2021 онд Хөөвөр 1-р баг малчдын тоо 119, үүнээс төлсөн малчид 45, мөнгөн дүн 7,964,200 мянган төгрөг байна. Төлөөгүй 74 малчин өрхийн төлөх дүн нь 11,943,300 мянган төгрөг байна. Гучин 2-р баг нийт малчин өрхийн тоо 125, төлсөн малчин өрх нь 54, мөнгөн дүн 9,044,700 мянган төгрөг, төлөөгүй малчдын тоо 71, мөнгөн дүн 9,927,000 мянган төгрөг байна. Аргалант 3-р баг нийт малчдын тоо 152, төлсөн малчин өрх нь 65, мөнгөн дүн 10,238,500, төлөлт хийгдээгүй малчин өрх 87, мөнгөн дүн 14,161,600 байна.Аргуут 4-р баг нийт малчин өрх нь 67, төлсөн малчид нь 18, мөнгөн дүн 1,251,100 мянган төгрөг, төлөөгүй малчин өрх нь 49, мөнгөн дүн 5,179,900 мянган төгрөг байна.

2022 онд Хөөвөр 1-р баг 119 малчин өрхөөс төлөлт хийсэн өрх нь 40, мөнгөн дүн нь 9,115,500 мянган төгрөг, төлөөгүй малчин өрхийн тоо 79, мөнгөн дүн 17,904,900 мянган төгрөг байна.Гучин 2-р баг 125 малчин өрхөөс татвараа төлсөн 48, мөнгөн дүн 9,460,000 мянган төгрөг, төлөөгүй 77 өрх, мөнгөн дүн нь 16,754,400 мянган төгрөг.Аргалант 3-р баг малчин өрх 152, төлсөн өрх нь 56, мөнгөн дүн нь 13,977,700 мянган төгрөг, төлөөгүй өрх 96, мөнгөн дүн 20,479,100 мянган төгрөг,Аргуут 4-р баг нийт малчин өрх 67, татвараа төлсөн өрх нь 24, мөнгөн дүн 3,521,500 мянган төгрөг, төлөөгүй малчин өрх 43, мөнгөн дүн 4,736,500 мянган төгрөг тус тус байна.

2023 онд Хөөвөр 1-р баг нийт 119 малчин өрхөөс 50 өрх татвараа төлсөн, мөнгөн дүн нь 14,399,300 мянган төгрөг, төлөөгүй 69, мөнгөн дүн 20,490,500 мянган төгрөг. Гучин 2-р баг нийт 125 малчин өрхөөс 66 өрх төлөлт хийсэн, мөнгөн дүн нь 19,501,000 мянган төгрөг, төлөөгүй малчин өрх нь 59, мөнгөн дүн нь 18,178,400 мянган төгрөг байна.Аргалант 3-р баг нийт малчин өрх 152 үүнээс татвараа төлсөн 73, мөнгөн дүн нь 20,424,400 мянган төгрөг, татвараа төлөөгүй 79 өрх, мөнгөн дүн нь 19,286,400 мянган төгрөг байна.Аргуут 4-р баг нийт малчин өрх 67, татвараа төлсөн нь 30, мөнгөн дүн нь 3,452,500 мянган төгрөг, төлөөгүй малчин өрх нь 37, мөнгөн дүн нь 6,158,100 мянган төгрөг байна.

2024 онд Хөөвөр 1-р баг 119 малчин өрхөөс татвараа төлсөн 89, мөнгөн дүн нь 24,018,400 мянган төгрөг, төлөөгүй малчин өрх 30 мөнгөн дүн нь 1,464,200 мянган төгрөг, Гучин 2-р баг 125 малчин өрхөөс татвараа төлсөн 117, мөнгөн дүн нь 24,161,700 мянган төгрөг, төлөөгүй малчдын тоо 8, мөнгөн дүн нь 1,627,900 мянган төгрөг, Аргалант 3-р баг 152 малчин өрхөөс татвараа төлсөн 152, мөнгөн дүн нь 29,071,000 мянган төгрөг, Аргуут 4-р баг 67 малчин өрхтэйгөөс татвараа төлсөн 43, мөнгөн дүн нь 5,902,501, төлөөгүй малчин өрх 23, мөнгөн дүн нь 1,708,099 мянган төгрөг байна. Иргэд та бүхэн татвараа Киоск, пос терминалаар төлөх, бүх банкны интернэт банк ашиглан цахимаар төлөх, банкны үйлчилгээний салбарт хандан төлөх боломжууд байна. Анхаарал хандуулсанд баярлалаа. Асуух зүйл байвал асууж болно.

Санхүүгийн албаны дарга Д.Нэргүй танилцуулга хийнэ.15 минутаас дээшгүй байна.

Д.Нэргүй:Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.Малын тоо толгойн албан татвараар санхүүжүүлэх 12 ажлын чиг үүрэг байдаг.Үүнийг танилцуулъя.

- 1.Бэлчээрийн менежментийг сайжруулах
- 2.Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх
- 3.Малын эрүүл мэндийг хамгаалах
- 4.Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
- 5.Малын чанарыг сайжруулах
- 6.Гэмт халдлага, гамшгаас хамгаалах

- 7.Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх
- 8.Малын тэжээлийн ургамал тариалах
- 9.Тэжээлийн нөөц бүрдүүлэх
- 10.Байгаль орчныг хамгаалах
- 11.Байгаль орчныг хамгаалах

12.Хортон мэрэгчидтэй тэмцэх гэсэн энэ 12 үзүүлэлтэд л дээрх татварыг зарцуулж болно гэсэн сангийн сайдын тушаалаар батлаад өгсөн боловч ОНХС-нд иргэд та бүхний өгсөн саналыг үндэслэн багийн Засаг дарга иргэдийн ирүүлсэн саналыг сумын Засаг даргад уламжилж, сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийж хэрэгжүүлэх ажлыг эрэмбэлж өгснөөр энэ төсөв санхүүждэг байгаа.Тийм учраас иргэд та бүхэн ОНХС-ийн хөрөнгө оруулалт малын тоо толгойн албан татвараар хийж байгаа ажлын саналыг баг баг дээрээ ярилцаж эрэмбэлснээр энэ төсөв бүрддэг байгаа.Одоо та бүхэнд малын тоо толгойн албан татвараар 2021-2024 онуудад ямар бүтээн байгуулалт хийсэн бэ гэдгийг танилцуулъя.

2021 онд Малын тоо толгойн албан татварын төлөвлөгөөг ИТХ-аас 69.7 сая төгрөгөөр баталж, 28.2 сая төгрөгийн татварын орлогын гүйцэтгэл орж, кронотой холбоотойгоор зарцуулалт хийгдээгүй.

2022 онд Малын тоо толгойн албан татварын төлөвлөгөөг ИТХ-аас 98.2 сая төгрөгийн төлөвлөгөө батлагдаж, татварын орлого 36.2 сая, өмнөх оны үлдэгдэл 28.2 сая төгрөг, санхүүжилтийн нийт дүн 64.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй.Дараах ажлуудыг хийх төлөвлөгөө баталсан.Үүнд:

- ✓ Сумын тэжээлийн нөөц бүрдүүлэх-65.2 сая төгрөг
- ✓ Малын тэжээлийн ургамал тариалах 15.0 сая төгрөг
- ✓ “Монголын хоолой”-н хүрэн тэмээг омог болгон батлуулах ажил 5.0 сая төгрөг

✓ Худаг засвар 13.0 сая төгрөг нийт 98.2 сая төгрөгийн ажил гүйцэтгэхээр төсөв батлагдаж дараах ажлуудыг хийсэн.

Их, бага үнэгтэд 2 ширхэг инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргасан. “Баянговь-Ус” ХХК 100 хувь гүйцэтгэсэн.

• Малын тэжээлийн ургамал тариалах, үр худалдан авч ногоон тэжээл тариалав. Төсөвт өртөг нь 8.5 мянган төгрөг, Гэрээний дүн 8.5 мянган төгрөг, Малын тэжээлийн ургамлыг 10 га-д тариалж 1200 боодол ногоон тэжээл хураасан. “Есөн ган хүлэг” хоршоо 100 хувь гүйцэтгэсэн.Уг ажлыг хийхэд малын тэжээлийн ургамал “Есөн ган хүлэг” хоршоотой гэрээ байгуулан Аргалант 3 дугаар багийн нутагт 10 га газрыг хагалж үр суулгалтыг 2.5 сая төгрөгөөр хийлгэсэн.

• Сумын өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх төсөвт өртөг нь 102.9 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч “Зүлэг агро” ХХК-тай 48.5 сая төгрөгөөр гэрээ хийж, өвс болон малын тэжээл худалдан авч малчдад үнэгүй тараасан.

• Монголын хоолойн тэмээг омог болгох судалгааны ажилд мал эмнэлэг эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтарч 1,500 тэмээнд хавар намрын ангилалтыг ОНХС-ийн 4.0 сая төгрөгийн санхүүжилтээр МААЭШХ-ийн батлагдсан судалгааны дагуу ангилалтын ажил хийгдэж цөм сүрэг бүрдүүлэх, ноос, мах, сүү, бэлчээрийн дээж, арьсны гистологийн бүтэц зэргийг судлуулах ажлууд хийгдсэн.Уг ажлыг МААЭШХ-ийн ажилтан, аймгийн ХХААГ-ын мэргэжилтэн, сумын Засаг даргын захирамжаар

томилогдсон ажлын хэсэг "Түсэг хайрхан" мал үржүүлэг технологийн нэгж хамтран явуулсан. Тус ажилд сумын 4 багийн 24 малчин өрхийн 1,500 тэмээнд хийсэн. Үржлийн сүрэгт 165, хэрэгцээний сүрэгт 55, цөм сүрэгт 1250 тус тус хамрагдав.

- Инженерийн хийцтэй худаг "Баянговь-Ус" ХХК-тай гэрээ байгуулж инженерийн хийцтэй, гүн өрмийн 2 ширхэг худаг 14.0 сая төгрөгөөр "Зүүн хавирга", "Олон худаг"-т гаргасан.

2023 оны санхүүжилтийн төлөвлөгөөнд Малын тоо толгойн албан татварын төлөвлөгөө нь 105.0, өмнөх оны үлдэгдлээс 9.5 сая нийт 114.5 сая төгрөгийн төлөвлөгөө батлагдаж, 57.8 сая төгрөгийн татварын орлого орсон. Дараах ажлуудыг төлөвлөсөн. Үүнд:

- ✓ Инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах 29.0 сая төгрөг
- ✓ Малын тэжээлийн ургамал тариалах, үр худалдан авах 10.0 сая төгрөг
- ✓ Монголын хоолойн тэмээний судлагааны ажлыг үргэлжлүүлэх 19.5 сая төгрөг
- ✓ Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах 19.9 сая төгрөг
- ✓ Үүлэнд нөлөөлж хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх 15.2 сая төгрөг
- ✓ Малын үүлдэр угсааг сайжруулах 15.9 сая төгрөг
- ✓ Малчдад сургалт хийх 5.0 сая төгрөг нийт 114.5 сая төгрөгийн төсөв батлагдаж дараах ажлуудыг хийсэн.

- Үүлэнд нөлөөлж хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх ажил төсөвт өртөг нь 15.2 сая төгрөг, гэрээний дүн 11.2 сая төгрөг, гүйэтгэгч "Нар хур трейд" ХХК-тай гэрээ хийн "Бороожуулагч тоног төхөөрөмж"-ийг 11.2 сая төгрөгөөр худалдан авсан.

- Инженерийн хийцтэй 2 ширхэг гүн өрмийн худаг харьцуулалтын аргаар цахим тендер зарлаж "Баянговь-Ус" ХХК 65.0 сая төгрөгөөр шалгарч "Их үнэгт", "Бага үнэгт"-д гаргасан.

- Малын тэжээлийн ургамал тариалах үр худалдан авах ажил "Есөн ган хүлэг" хоршоотой 8.5 сая төгрөгөөр гэрээ хийн 10 га газарт малын тэжээлийн ургамал тариалах үрийг суулгасан.

- Малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор Сүхбаатар аймгийн Эрдэнэ цагаан сумаас Үзэмчин үүлдэрийн хуцыг 15.0 сая төгрөгөөр "Ихэр загал" ХХК-тай гэрээ хийн 25 ширхэг залуу хуцыг малчдад гэрээгээр нийлүүлсэн.

- Шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт "Өөш шахлаг" мал эмнэлгийн нэгжтэй гэрээ хийн ишгийг шөвөг ярь өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг 7.0 сая төгрөгөөр 13,919 толгой ишиг хамруулсан.

- Үхрийн шүлхийн вакцинжуулалт "Өөш шахлаг" мал эмнэлгийн нэгжтэй гэрээ хийн үхэрт шүлхийн вакцин 2.959.7 мянган төгрөгөөр хавар, намрын улиралд давхардсан тоогоор 5,746 үхрийг вакцинжуулсан.

- Төл малыг бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт "Өөш шахлаг" мал эмнэлгийн нэгжтэй гэрээ хийн төл малыг бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин 2.0 сая төгрөг зарцуулж 35,114 толгой хурга ишгийг вакцинжуулсан.

- Монголын хоолойн хүрэн тэмээг омог болгон батлуулах ажил үргэлжлүүлэн хянан баталгаа 2.2 сая төгрөг, сүү цусны дээжийн шинжилгээнд 1.2 сая төгрөг,

шатахуун 0.5 сая төгрөг, томилолт 2.7 сая төгрөг зарцуулж гүйцэтгэлийн ажил 90 хувьтай явж байна.

2024 онд малын тоо толгойн албан татварын төлөвлөгөө 119.0 сая төгрөг батлагдаж гүйцэтгэл 83.2 сая төгрөгийн орлого орсон. Дараах ажлуудыг төлөвлөсөн.

- ✓ мал ариутгалын автомашин
- ✓ Худаг ус гаргах 20.0 сая төгрөг,
- ✓ Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх- 19,0 сая төгрөг
- ✓ Өвс тэжээл худалдан авах 12.0 сая төгрөг
- ✓ Малын тэжээлийн ургамал тариалах 15.0 сая төгрөг
- ✓ Монголын хоолойн тэмээг омог болгон батлуулах ажил 10.0 сая төгрөг тус тус төлөвлөсөн.

• Малын тэжээлийн ургамал тариалах үр худалдан авах 14.3 сая төгрөгөөр “Өнөхонгор” ХХК, “Амин аргуйт дундын тариалалт” ХХК-тай гэрээ хийж авсан.

• Худаг гаргах, засварлах гүн өрмийн 2 худаг, 1 цооног, 2 худаг засварлах ажил 79.0 сая төгрөгийн тендерийг харьцуулалтын аргаар зарлаж “Баянговь-Ус” ХХК шалгарч “Монголын хоолой”-д “Арлын далан”, “Зүүн нүхт”-д “Шавар овоо” худгуудыг иж бүрэн шинээр гаргасан. Сумын төвөөс зүүн хойш “Цахирын олон худаг”, гүн өрмийн цооног гаргасан. “Талын тээг” худгийн засварласан. Худаг ус засварлах 79.0 сая төгрөгөөс малын тоо толгойн татвараас 20.0 сая төгрөг нь гарсан.

• Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах “Их-Угалз” ХХК, “Зи Пи Эл Ди” ХХК-уудтай гэрээ хийн 7.0 сая төгрөгөөр 14,000 толгой ишгэнд шөвөг ярь өвчнөөс урьдчилан сэргийлж вакцинжуулсан. Цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх 58,813, бог малын мялзан өвчнөөс 4,553, шүлхий өвчнөөс 1,580 толгой малыг урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад тус тус хамруулахад 6.8 сая төгрөгийн шатахууны зардал гарсан. Цагаан хорхойны туулгалтад Их-Угалз ХХК-тай гэрээ хийн 3.6 сая төгрөгөөр 34,994 толгой бог малд дотор туулгалт хийсэн.

• Мал ариутгалын автомашин худалдан авсан. Харьцуулалтын аргаар мал ариутгалын автомашин худалдан авах тендерт “Жапанкапатс” ХХК 42.2 сая төгрөгөөр шалгарч 4 талаараа ариутгадаг автомашинтай болсон. Анхаарал хандуулсанд баярлалаа. Асууж тодруулах зүйл байвал асууж болно.

Сонсгол даргалагч Ц.Наранбаатар: Мэдээлэлтэй холбогдуулан бүртгүүлсэн дарааллаар асуулт асууна, асуултын хариуг өгөөд явна. Асуулт асуух хугацаа 4 минут.

С.Даваадолгор: Сайн байцгаана уу? бүгдэд нь өдрийн мэнд. Татварын талаар асуулт асууя. 2021-2024 оны 1,2,3,4, дүгээр багийн өрхийн тоо өөрчлөгддөггүй юм уу?, бүх онуудад өрхийн тоо хэвээр байх юм. Шилждэг, гэр бүл болж байна. Шилжих хөдөлгөөн хийгдээгүй байдаг юм уу?

А.Самбуу: Ер нь дээд газраас малын тоо толгойн албан татварыг бүрэн төлүүл гэдэг чиглэл ирж байгаа. Зарим тохиолдолд иргэдийн дансыг хаах хүртэл арга хэмжээ авагдаж байна. Сүүлийн жилүүдэд энэ талын ажил сайн хийгдэж байгаа гэж бодож байна. Харин энэ өрхийн тооны хувьд бол засах залруулах зүйл байна. Цаашдаа анхааран ажиллана.

С.Даваадолгор: Олон жил татвараа төлөөгүй иргэдэд ямар арга хэмжээ авдаг вэ?

А.Самбуу:Татварын хүрээнд бол олон жилийн төлөлттэй иргэдэд данс хаах л арга хэмжээ байдаг.Бид бол аль болох данс хаахгүйгээр иргэдтэй ярьж төвлөрүүлэхийг хичээж ажиллаж байгаа шүү.Данс хаана гэдэг нь иргэдийн дансанд орсон мөнгөнөөс шууд таталт хийх арга хэмжээ байдаг.Бусад суманд нэлээд данс хаах арга хэмжээ авч байна.Манай суманд бол 2 иргэний данс хаагдсан байна.

С.Даваадолгор:Энэ 12 чиг үүргийг иргэд хэр сайн мэддэг вэ?, энэ чиг үүргийг иргэдэд мал тооллогоор ч юм уу явахдаа тайлбарлаж сургалт хийж болох уу?

Д.Нэргүй:Цахимд нэлээд мэдээлэл оруулдаг шүү.Хэдий энэ 12 чиг үүргийг сангийн сайд батлаад явсан ч иргэдийн эрх мэдлийн хүрээнд хийдэг.Энэ чиг үүрэгт байхгүй иргэдийн саналыг ирүүлээгүй төсөл арга хэмжээг хуулиараа хориглосон байдаг шүү.

3.Мөнхбаяр:Энэ материалд хөдөөгийн хүн гэсэн үг өгүүлбэр нь ямар учиртай юм бэ?

Д.Нэргүй:Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх гэсэн дээр хөдөө амьдардаг иргэдийн усан хангамж болоод бэлчээрийн усан хангамж нэмэгдүүлнэ гэсэн үг шүү.Сумын төвд бол энэ худаг гаргаж болохгүй гэдэг.Заавал хөдөө гаргасан байх ёстой.

3.Мөнхбаяр:Хөдөө амьдардаг хүн гаргах юм уу?

Д.Нэргүй:Энэ нь хуулиндаа ингэж бичигдсэн үг шүү.

М.Сандолгор:Энэ мал угаалгын машин нь 2024 онд мал ариутгуулах гэсэн чинь машин нь саатсан гээд угаагаагүй.Одоо энэ жил 2025 онд угаагдах уу?

Х.Энхтайван:Мал ариутгалын машины хувьд бид сумандаа малаа ариутгахаар аль болох сүүлийн үеийн машиныг сонгож авчруулсан юм.Одоо малыг ваннд ариутгаж болохгүй гээд байгаа.Уг машин нь өөрөө 4 талруугаа цацаж ариутгадаг машин юм.Тухайн үед бид буруу ажиллуулаад баг зэргийн эвдрэл гарч байсан.Одоо зүгээр ажиллана.

3.Мөнхбаяр:Энэ 2021 оны 28.2 сая төгрөгийн гүйцэтгэл яагаад 2022 он руу шилжсэн шалтгаан нь юу вэ?

Д.Нэргүй:Тухайн үед 2021 онд 28.2 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан боловч ажил хийгдээгүй нь тэр үед хөл хорио тогтоосон байсантай холбоотойгоор хийгдээгүй.

О.Батмөнх:2023 онд малын үүлдэр угсааг сайжруулна гэсэн байна.Энэ малын тоо толгойн албан татвараас хийгдсэн Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумаас авчирсан хуцыг иргэдэд нэг хуцыг 4 төлгөөр олгосон байдаг.Энэ талаар хариулт авъя.Малын тоо толгойн татвараас хийгээд буцаагаад иргэдээс авдаг юм уу?

Х.Энхтайван:Энэ мөнгө нь өөрөө буцааж хийгдэх ёстой мөнгө байсан юм.Тиймээс бид иргэдэд тухайн үедээ гэрээ байгуулж нэг хуцыг 4 төлөг гэж тараасан боловч очиж худалдаж авсан үнээ ч бариагүй.


Сонсгол даргалагч Ц.Наранбаатар:За та бүхэнд санал байхгүй бол саналаа тасалъя.Хэлэлцүүлэгтээ холбогдуулж оролцогчдоос дүгнэлт хэлэх хүн байна уу?

С.Даваадолгор:Малын тоо толгойн албан татварыг зарим иргэд өгөөд зарим иргэд өгдөггүй юм байна.Энэ дээр иргэдийг татвараа төлүүлэх төлөвлөгөө гаргаж ажиллах хэрэгтэй.Мөн малчин иргэдийн тоог үнэн зөв гаргаж байгаарай.

Сонсгол даргалагч Ц.Наранбаатар:Энэ удаагийн нийтийн сонсголын үйл ажиллагаа амжилттай явагдаж өндөрлөлөө.

Оролцогч, ажиглагч, мэдээлэл өгсөн төрийн албаны байгууллага хүмүүс та бүхэндээ баярлалаа.

Сонсголын үйл ажиллагаа хаасныг мэдэгдье. Та бүхэнд баярлалаа.
Нийтийн сонсгол 15 цаг 40 минутад өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН  Ц.НАРАНБААТАР
(ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧ, СОНСГОЛ ДАРГАЛАГЧ)
ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН  Д.БОЛОРЧИМЭГ
(ИТХ-ЫН МЭРГЭЖИЛТЭН)

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ГУЧИН-УС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛААС ЗОХИОН БАЙГУУЛСАН НИЙТИЙН СОНСГОЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 10 дугаар сарын 29

№2025/03

Гучин-Ус сум

Нийтийн сонсгол Гучин-Ус сумын соёлын төвд 2025 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 12 цагт 51 минутад эхлэв.

Нийтийн сонсголын сэдэв: “Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол хөтөлбөрийн төсвийн зарцуулалт”-д хийх төсвийн хяналтын сонсгол.

Сонсгол даргалагчаар Төсөв, санхүү эдийн засгийн бодлогын хорооны төлөөлөгч Ц.Наранбаатар ажиллаж оролцлоо.

Сонсголд тайлбар мэдээлэл өгөхөөр дуудагдсан төрийн байгууллага, албан тушаалтнаар:

1. Х.Энхцацрал (ЕБС-ийн захирал)
2. Б.Даваажаргал (ЕБС-ийн бага ангийн сургалтын менежер)
3. Х.Чулуунбаатар (ЕБС-ийн нягтлан)
4. Н.Нарансамбуу (ЕБС-ийн нярав)

Хүрэлцэн ирээгүй албан тушаалтан байхгүй, бүгд ирсэн байна.

Журмын дагуу бүртгүүлж оролцох оролцогчдыг танилцуулъя. Үүнд:

1. Сонсголд оролцож санал хэлэх, тайлбар, мэдээлэл өгөх оролцогчоор
 - Б.Нямдаваа- 2-р багийн ИНХ-ын дарга
 - Б.Цэвэлмаа (1-р багийн иргэн)
 - Ц.Жавзандулам (2-р баг иргэн)
 - Л.Даваасүрэн (малчин)
 - Ч.Чулуунцэцэг (малчин)
 - Т.Пүрэвжаргал (4-р багийн иргэн)
 - Д.Баярсайхан (ЭМТ-ийн жолооч)
 - Гаарамба (2-р баг малчин)
 - С.Доржсүрэн (4-р багийн иргэн)
 - Н.Чүлтэмгямцай (1-р БЗД)
 - О.Батмөнх (малчин)
 - Ц.Мөнхзаяа (3-р баг)
 - Е.Алтанцэцэг (2-р баг)
 - Д.Үүрцайх (багш)
 - Б.Баасансүрэн (3-р баг)
 - Д.Сэмжаан (2-р баг) нар оролцож байна.

Ажиглагчаар нийт 10 хүн бүртгүүлснээс 5 иргэн ирсэн байна.

Сонсгол даргалагчийн зүгээс заавал оролцуулахаар урьсан олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, тухайн асуудлаар мэргэшсэн мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага байхгүй болно.

Сонсгол даргалагч Ц.Наранбаатар сонсголын дэгийг танилцуулав.

Сонсголд дуудагдсан оролцогч “Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол хөтөлбөрийн төсвийн зарцуулалт”-ын талаар ЕБС-ийн нягтлан Х.Чулуунбаатар танилцуулга хийнэ. 15 минутаас дээшгүй байна.

ЕБС-ийн үдийн хоол хөтөлбөрийн талаар бага ангийн сургалтын менежер Б.Даваажаргал мэдээлэл хүргэнэ. 15 минутаас хэтрэхгүй байна.

Б.Даваажаргал (ЕБС-ийн бага ангийн сургалтын менежер): Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Бага ангийн үдийн хоол хөтөлбөрт манай сургууль 160 сурагч, тусгай хэрэгцээт боловсролын 6 сурагч хамрагддаг. Үдийн хоолонд өдөрт нэг сурагч 2500 төгрөг зарцуулдаг. Үдийн хоолны цэс нь 14 хоногт давхардахгүй байхаар

боловсруулагддаг. Аймгийн хэмжээнд үдийн хоолны нэгдсэн нэг цэстэй болсон байгаа. Манай сургууль “Өдөр бүр 1 аяга сүү” хөтөлбөрийг 2025 оны 03 дугаар сарын 01-нээс 05 дугаар сарын 01-ны хугацаанд 6-р ангид эцэг эхийн 1.8 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн. Уг хөтөлбөрийн хүрээнд 7 хоногт 2 удаа хоолны менунд оруулж өгч байгаа. Үдийн хоол амталгаанд эцэг эхийн төлөөлөл, удирдлага, дотоод хяналтыг тогтмолжуулж ажиллаж байна. Үдийн хоолны дээжийг мөн тогтмол авч, устгалд тогтмол оруулж тэмдэглэл хөтөлдөг. Тогооч үйлчлэгч нар үйл ажиллагааны дэвтэр хөтөлж хэвшсэн. За мөн сэтгэл ханамжийн судалгааг авч ажилласан байгаа. Доорх 6 асуумжаар авсан. Үүнд:

1. Үдийн хоолонд орохдоо өөрийн аягаар иддэг үү? Гэсэн асуултад 4 хүүхэд буюу 0.9 хувь нь гал тогооны аягаар иддэг гэж хариулсан байна. Манай сурагчид өөрсдийн аягатай болсон байгаа. Энэ нь судалгаа авдаг өдөр аягаа орхиж ирсэн сурагчид байсан.

2. Үдийн хоолонд амин дэмтэй хоол өгдөг үү? Гэсэн асуултад тогтмол өгдөг 66 хувь, хааяа өгдөг 22 хувь, ихэнхдээ 12 хувьтай өгсөн байсан. 1-5 дугаар ангийн сурагчдаас авсан судалгаа байгаа.

3. Үдийн хоолны тогооч нарын харилцаа хандлага ямар вэ? гэдэг дээр сайн 54 хувь, дунд 42 хувь, муу 4 хувьтай өгсөн байна.

4. Үдийн хоолны тогооч эгч нь дүрэмт хувцсаа өмсдөг үү? Гэсэн асуултад тогтмол 55 хувь, хааяа 39 хувь, өмсдөггүй 6 хувьтай байна. Ерөнхийдөө манай тогооч нарын хувьд дүрэмт хувцас амны хаалт, малгай, иж бүрэн хувцастай болсон байгаа. Энэ дээр яг журмын дагуу хувцсаа өмсөөд явж байгаа.

5. Тогооч нартаа баярлалаа гэж хэлдэг үү? Гэсэн асуумжид тогтмол хэлдэг 65 хувь, хааяа хэлдэг 30 хувь, хэлдэг сонсдоггүй 5 хувьтай байна.

6. Тогооч та нартай мэндэлдэг үү? Гэсэн асуумжид мэндэлдэг 63 хувь, мэндэлдэггүй 14, хааяа мэндэлдэг 23 хувьтай байна. Мөн тогооч багш нартаа хандаж хэлэх сэтгэлийн үг бичүүлсэн байгаа. Үүнд: Гоё хоол хийж өгдөгт баярлалаа 35 хүүхэд, тогооч багш нартаа хайртай шүү, та яагаад ийм гоё хоол хийдэг юм бэ?, ажилд чинь амжилт, мах нь өөх их, том том давтсан, дандаа эрүүл хоол иддэг гэсэн сурагчдаас сэтгэл ханамжийн судалгаа байдаг. Мөн дараа нь эцэг эхээс авсан байгаа. Түүврийн аргаар хийгддэг. Ерөнхийдөө 2-5 дугаар ангийн эцэг эхчүүдээс авсан. Нийтдээ 30 эцэг эх хамрагдсан. Дараах асуумжаар. Үүнд:

1. Та хүүхдийнхээ үдийн хоолонд амталгаа хийдэг үү? Гэсэн асуумжид тогтмол хийдэг 24 хувь, хааяа 14 хувь, огт үгүй 12 хувь, багшийг дуудсан үед 50 хувь хийдэг.

2. Үдийн хоол үйлдвэрлэлийн талаар хэр мэдээлэлтэй вэ? гэсэн асуумжид мэдээлэл сайн авдаг 58 хувь, мэдээлэл бага 25 хувь, огт мэдээлэлгүй 4 хувь, хүүхдээсээ асууж 4 хувь гэсэн байна.

3. Үдийн хоол үйлдвэрлэлд таны сэтгэл ханамж ямар байдаг вэ?, маш сайн 63 хувь, дунд 27 хувь, хангалтгүй 10 хувьтай байна.

4. Үдийн хоолны амт чанар хүрэлцээ ямар вэ? гэсэн асуумжид маш сайн 62 хувь, сайн 25 хувь, дунд 9 хувь, хангалтгүй 4 хувь тус тус байна. Энэ судалгаанаас дүгнээд үзэхэд ерөнхийдөө эцэг эхчүүд хүүхдийнхээ эрүүл аюулгүй хүнс хэрэглэж байгаад анхаарах хэрэгтэй, өнөөдөр манай хүүхдүүд ямар ямар шим тэжээлт хоол хүнс авах ёстой вэ гэдэгээ анхаарах хэрэгтэй, үдийн хоол үйлдвэрлэлд ямар төрлийн хоол өгч байгааг мэддэг байх хэрэгтэй, үдийн хоол үйлдвэрлэлийн мэдээлэл өгдөг байх хэрэгтэй, үдийн хоол үйлдвэрлэлд эцэг эхийн хяналт оролцоог сайжруулах гэсэн дүгнэлт гарсан байна. За анхаарал хандуулсанд баярлалаа.

Ц.Наранбаатар (сонсгол даргалагч): За одоо та бүхэнд ЕБС-ийн нягтлан бодогч Х.Чулуунбаатар төсвийн талаар мэдээлэл хүргэнэ.

Х.Чулуунбаатар (ЕБС-ийн нягтлан бодогч): За та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Үдийн хоол хөтөлбөр нь Монгол улсын засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны 254 дугаар тогтоолоор хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын

хэмжээг шинэчлэн тогтоох тухай гэсэн тогтоол гарсан байгаа. Энэ дээр нэг хүүхдийн хоолны зардал 2500 төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хоолны зардал 3400 төгрөгөөр тогтоогдсон байгаа. 2025 онд батлагдсан төсөв нь 70,2547,700 мянган төгрөг байсан. Үүнээс хасах тодотгол хийгээд 10,256,000 мянган төгрөг хасагдаж одоогийн төсөв нь 59,616,200 төгрөг болсон. 1-9 сард баталсан нь 45,567,000 гүйцэтгэл нь 37,427,500 мянган төгрөг, үлдэгдэл нь 8,032,600 мянган төгрөг байна. Тендер зарлагдаж 1 компани материал ирүүлж Өгөөмөр эрдэнэ хайрхан ХХК-тай гэрээ байгуулж бэлтгэн нийлүүлэгч хийж байна. Оны эхний үлдэгдэл нь 3,991,721 төгрөг, 9 сарын орлого нь 47,427,000 мянган төгрөг, зарлага нь 39,632,000 мянган төгрөг, үлдэгдэл нь 985,675 мянган төгрөг байна. Нэг сарын хоолны нийт зардал нь 2,767,560 үүнээс нийт ирсэн хүүхэд нь 1107 гээд норматив нь 2500, 2 сард 7,230,0 мянга ирсэн хүүхэд нь 2855, норматив нь 2500 мянган төгрөг, 3 сард 6,928.0 мянган төгрөг ирсэн хүүхэд нь 2447, норматив нь 2500, 4 сард 4045000 мянган төгрөг ирсэн хүүхэд нь 1598, норматив нь 2500, 5 сард 7,193.0 мянган төгрөг, ирсэн хүүхэд нь 2902 хүүхэд, норматив нь 2479, 6 сард 3,407,500 мянган төгрөг, ирсэн хүүхэд нь 1363, норматив нь 2500, 9 сард 7,106,800 хүүхдийн тоо 3200, норматив нь 2500 гээд нийт хөлийн дүн нь 2500 төгрөгөө барьж байгаа. Нийт зарлага нь 39,632,140 төгрөгийн зарлагатай байгаа. Сар болгон хоолны төлөвлөгөө гаргадаг. Тэр нь өдөр өдөртөө бичиж байгаа шаардах хуудастайгаа таарч явдаг. Эдгээрийг үзье гэвэл үзэж болно. Жишээ нь 2 сарын 24-нд 149 хүүхэд ирсэн гэвэл яг мөнгөн дүндээ тааруулж хүнсээ бичээд энэ нь яг таараад явдаг. За ингээд миний ярих танилцуулах зүйл болсон.

Сонсгол даргалагч Ц.Наранбаатар: Мэдээлэлтэй холбогдуулан бүртгүүлсэн дарааллаар асуулт асууна, асуултын хариуг өгөөд явна. Асуулт асуух хугацаа 4 минут.

С.Доржсүрэн: Сайн байцгаана уу? бүгдэд нь өдрийн мэнд. Хүнсний ногоог хаанаас авдаг вэ?

Х.Чулуунбаатар: Нийлүүлэгч дэлгүүрээс авдаг. Өгөөмөр Эрдэнэ хайрхан дэлгүүрээс авдаг.

С.Доржсүрэн: Нутгийнхаа хөрсөнд тарьж ургуулсан хүнсний ногоог хэрэглэж байж болдоггүй юм уу?

Х.Чулуунбаатар: Байнга нийлүүлэх хүн байвал болох ч манайд тийм иргэн ховор юм. Тиймээс бид тендерт шалгарсан компаниас л хүнсний ногоог нийлүүлж байгаа.

Н.Чүлтэмгямцай: Энэ сүүг хаанаас нийлүүлдэг вэ?, Сумын төвийн үхрүүд өдийд хогийн дэнж дээр л өнждөг бид мэднэ. Түүнийг орой ирэхээр нь дэлэн хөхийг угаагаад саадаг иргэн ховор л байгаа. Тэр сүүг бидний ирээдүй хүүхдүүд хэрэглэж байгааг анхаараарай. Ямар ч эрүүл ахуйн шаардлага хангаагүй байна.

Б.Даваажаргал: Бид урд нь ямааны сүү нийлүүлж байсан. Сая 9 сараас боловсролын газраас тетрадан савлагаатай тусгай сүүг нийлүүлж байгаа. Гарал үүслийн бичигтэй аймгийн боловсролын яамнаас ийм сүү хэрэглэх чиглэл өгч байгаа.

Б.Сэмжаан: Хүүхдийн хоолны норматив хэмжээ батлахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусгай мөнгөн дүн батлагдсан байна. Энэ нь бодит байдал дээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд яг тусад нь хоол өгдөг гэсэн үг үү?

Х.Чулуунбаатар: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хоолны орц арай илүү байдаг.

Б.Даваажаргал: Хоолны илчлэг кл калориор бодох юм бол 1-5 дугаар ангийн хүүхэд 500-530 кл калиор гэдэг ч юм уу, 3-5 ангийн хүүхэд 573-619 грамм, 5 дугаар анги нь 600 кл калиор авах ёстой байдаг. Энэ дээр ямар зохицуулалт байдаг вэ

гэхээр манайд бага анги 4 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, 5-р анги 2 хүүхэд байдаг. Эдгээр өгөх ёстой хэмжээ нь нэмээд бодогддог. Хоолны нэр төрөл тусгай хоол өгдөггүй. Хэмжээ кл калиор орц нь арай ахиу байна аа гэсэн үг юм.

Б.Чулуунцэцэг: Хоол хийдэг махыг хаанаас нийлүүлдэг вэ?, Иргэдээсээ авч болдоггүй юм уу?

Х.Чулуунбаатар: Нийлүүлэгч компаниас нийлүүлдэг. Иргэдээс нийлүүлж болно.

Б.Даваажаргал: Тендерт шалгарсан компани нь өөрөө нийлүүлээд явах ёстой. Гэхдээ иргэдээс нийлүүлэхээр бол махны гарал үүслийн бичиг л байдаг.Шинжилгээнд хамрагдсан байх ёстой гэсэн шаардлага л тавьдаг.

Ц.Жавзандулам: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хоолны мөнгө нь тусдаа батлагдсан байхад хоол нь хангалттай байдаг гэж бодож байна. Харин нэмж хоол өгөхийн оронд жимс ч юм уу? нэмэлтээр мөнгөн дүнд нь таарсан бүтээгдэхүүн өгч болдоггүй юм уу?

Б.Даваажаргал: Энэ дээр орцыг нэмж байгаа учраас тусгайлан хоол өгөх боломж байхгүй гэсэн үг юм.

Х.Чулуунбаатар: Өмнө нь бид өөрсдөө хоолоо менуг зохиогоод хийдэг байсан бол 9 сарын 1-ээс хойш аймгийн хэмжээнд нэгдсэн цэстэй болж тэрний дагуу бид хоолоо үйлдвэрлэж байгаа.

С.Мөнхтогтох: Тараасан материалд махыг шинжилгээнд явуулдаг гэсэн байна. Жилд ер нь хэдэн удаа шинжилгээнд явуулдаг вэ?

Х.Чулуунбаатар: Махыг өдөр тутамдаа явуулдаг.

Б.Цэвэлмаа: За бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Урд нь сүү хөтөлбөр хэрэгжүүлээд хүүхдүүдээ сүү өгдөг байсан гэсэн байна. Одоо 7 хоногт 2 удаа сүү өгдөг гэсэн байна. Энэ хөтөлбөр үргэлжлээд явж байгаа юу?, ямар хөтөлбөр хэрэгжүүлж байгаа вэ?

Б.Даваажаргал: Энэ нь энэ жилийн хувьд сүү хөтөлбөрийг санхүүжүүлэх төсөв байхгүй. Эцэг эх буюу бусад олон нийтийн санхүүжилтээр зохион байгуулагдаж байгаа. 3 дугаар сарын 1-ээс 5 дугаар сарын нэгнийг хүртэл сүү хөтөлбөр хэрэгжүүлж явсан. Одоо болохоор 9 сарын 1-ээс хойш 6 дугаар ангийн эцэг эхчүүдэд санал тавьж байгаа. Дэмжигдээгүй явж байгаа. Одоо бол 1-5 дугаар ангийн хүүхдүүдэд 7 хоногт 2 удаа сүү өгөөд явж байна.

Ц.Мөнхзаяа: Жижиг хоолны хөргөгч байдаг уу?, дээжийг хэдэн цагийн хугацаатай хадгалдаг вэ?, дээж цуглуулгын бүртгэлийн дэвтэр байдаг уу?, ямар тогтоол шийдвэр барьдаг вэ?, Мөн тараах материалын зурган дээрээс харахад пэйри байна. Уг пэйри нь хүний биед ямар хортой вэ гэдгийг бид мэднэ. Хүний биед ходоодонд ашигтай болон, ашиггүй бактериуд байдаг. Пэйриг хэрэглэсний улмаас хүний биеийн ашигтай бактери устаж байдаг. Энэ хэзээний зураг байна.

Н.Нарансамбуу: Стандартын зориулалттай жижиг мини хөргөгч байгаа. Хоолны дээжийг 72 цаг хадгалдаг. Бүртгэлийн дэвтэр байгаа. Үзэж болно. Энэ дээр үеийн зураг оруулсан байна.

Б.Даваажаргал: Дээж авсан тэмдэглэл, устгасан тэмдэглэл нь дотроо мөн заалтуудтай байгаа.

Ц.Мөнхзаяа: Боорцог чанасан тосоо ахиж ашигладаг уу?, хүүхдийн шүдний өвчлөл хоол боловсруулах замын өвчин үүсгэгч нь транс тос гэж яриад байгаа. Нэг боорцог чанаад дахин хэрэглээд байгаа тосыг л транс тос гээд байгаа. Тэр тосон дээр хяналт тавьж байсан уу?

Н.Нарансамбуу: Тосыг хэдэн удаа ашиглаж байгаа гэсэн бүртгэл хийгддэг. Ер нь нэг л удаа ашигладаг. Мөн малынхаа сүүлийг шаргааж ашиглаж байна.

Ц.Наранбаатар (сонсгол даргалагч): За иргэдэд хэлэх санал байна уу?

Д.Баярсайхан: Надад нэг санал байна. Тайлан их ойлгомжтой боллоо. Би нэг юмыг их боддог. ЕБС-ийн хүүхдүүдийн хуурай идэх юм гурилан бүтээгдэхүүнийг дэлгүүрээс худалдаж авах биш хийж өгөх тал дээр анхаараарай. Хүүхдүүдэд арай идэнгэтэй эрүүл байх юм.

Д.Үүрцайх: Тайлан ойлгомжтой байлаа гэж бодож байна. Та бүхэнд амжилт хүсье.

Х.Энхцацрал: Би нэг санал хэлье. Манай сургуулийн дотуур байрны хүүхдийн хоол үйлдвэрлэлийн заал шаардлага хангахгүй гээд бид үдийн хоол үйлдвэрлэлийн байранд нэгдсэн журмаар хоолоо хийж байгаа. Ийм учраас гурилан боов хийгээд байх нөхцөл нь бүрдэхгүй байгаа ч бид дотуур байрны хүүхдүүдэд гэрийн боорцог өгөөд хэвшсэн. Ноднингоос хойш ер нь дандаа дотуур байрны хүүхдүүд гэрийн боорцог иддэг. Бид намраас хойш жишиг цэс гарсан. Тэр цэсэнд боорцог бараг ороогүй байна. Сая бид Говь эрдэнэ бүсийн үйл ажиллагаатай байсан учраас тэр хэдхэн өдөр л үйлдвэрлэлийн боорцог өгсөн байгаа шүү.

Ц.Наранбаатар (сонсгол даргалагч): За та бүхэнд санал байхгүй бол саналаа тасалъя. Хэлэлцүүлэгтээ холбогдуулж оролцогчдоос дүгнэлт хэлэх хүн байна уу?

Б.Даваажаргал: Сонсголд оролцон биднээс хэрэгтэй мэдээллээ авч чадсан гэж бодож байна. Мөн нэмээд хэлэхэд хоолны цэс, мену нь сургуулийн дотор талд байнга ил гаргасан байдаг шүү.

Б.Цэвэлмаа: За баярлалаа. Бид ажлын нөхцөлөөс шалтгаалж гарч ороод байж чаддаггүй. Тиймээс хүүхдийн хоолны тэр өдрийн мену цэсийг групп дээр нь ч юм уу? оруулж өгч байгаарай. Сонсгол ил тод нээлттэй боллоо. Баярлалаа.

Ц.Наранбаатар (сонсгол даргалагч): Энэ удаагийн нийтийн сонсголын үйл ажиллагаа амжилттай явагдаж өндөрлөлөө.

Оролцогч, ажиглагч, мэдээлэл өгсөн төрийн албаны байгууллага хүмүүс та бүхэндээ баярлалаа.

Сонсголын үйл ажиллагаа хаасныг мэдэгдье. Та бүхэнд баярлалаа.

Нийтийн сонсгол 13 цаг 40 минутад өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН Ц.НАРАНБААТАР
(ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧ, СОНСГОЛ ДАРГАЛАГЧ)
ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН Д.БОЛОРЧИМЭГ
(ИТХ-ЫН МЭРГЭЖИЛТЭН)